

БАТЛАВ
“УБЦТС” ТӨХК-ийн ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ
Д.БАЯРСАЙХАН
2020 оны 01 сарын 22-ны өдөр

БАТЛАВ
“АЙ ТИ ЗОН” ХХК-ийн ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ
У.НАРАНБААТАР
2020 оны 01 сарын 22-ны өдөр

**ArcGIS- ын МЭДЭЭЛЛИЙН БААЗ ДЭЭР СУУРИЛСАН IT СИСТЕМ
НЭВТРҮҮЛЭХ (ТОДОТГОЛООР НЭМЭЛТ) НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ**

Дугаар № 2020/18

2020 оны 01 дүгээр сарын 22

Улаанбаатар хот

Нэг талаас “УБЦТС” ТӨХК (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас “АЙ ТИ ЗОН” ХХК (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь ArcGIS- ын мэдээллийн бааз дээр суурилсан it систем нэвтрүүлэх (цаашид “бараа” гэх)-ийг 474,282,600.0 (дөрвөн зуун далан дөрвөн сая хоёр зуун наян хоёр мянга зургаан зуу) төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх)-өөр нийлүүлж, суурилуулж, ашиглалтанд хүлээлгэн өгөхөөр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг 474,282,600.0 (дөрвөн зуун далан дөрвөн сая хоёр зуун наян хоёр мянга зургаан зуу) төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

4. Нийлүүлэгч нь ArcGIS- ын мэдээллийн бааз дээр суурилсан it системийг 2020 оны 01 дүгээр сарын 22-оос 2020 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн дотор нийлүүлж, суурилуулж, сургалт, зүгшрүүлэлт тохируулга хийж, ашиглалтанд оруулан хүлээлгэж өгнө.

5. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний бичиг баримт” гэх). Үүнд:

- (а) Энэхүү гэрээ болон түүний хавсралтууд
- (б) Гэрээний тусгай нөхцөл
- (в) Гэрээний ерөнхий нөхцөл
- (г) Техникийн шаардлага (Хэрэгжүүлэх хуваарь-ийг оролцуулана)
- (д) Нийлүүлэгчийн ирүүлсэн тендер, үнийн хуваарь
- (е) Бусад

ГЭРЭЭНИЙ ХАВСРАЛТУУД

- Хавсралт 1 Нийлүүлэгчийн төлөөлөгч
- Хавсралт 2 Зөвшөөрөгдсөн туслан гүйцэтгэгчид
- Хавсралт 3 Программ хангамжийн төрөл

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.

8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НИЙТЛЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛСЭН ДЭД
ЗАХИРАЛ




О.ОТГОНБАЯР

САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА



О.АРИУНБОЛД

ХАНГАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ДАРГА



Ш.ОЮУНЧИМЭГ

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН



Ц.ЭНХЦЭЦЭГ

утас: 342420-129

факс: 341671

хаяг: Хан-уул дүүрэг, 3-р хороо
Чингисийн өргөн чөлөө-45.

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

БИЗНЕС ХӨГЖҮҮЛЭЛТИЙН ХЭЛТСИЙН
МЕНЕЖЕР



М.МАЙБАЯР

Утас: 88119139, 77317731

Факс:

Хаяг: Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, бага
тойруу 14200-0049, Сүхбаатарын талбай-5,
Сити тауэр 4-р давхар.